**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/142/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугээр сарын 17 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: П.Амаржаргал<br>Утас: 88106992 Цахим хаяг: amarjargal.6992@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 12
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 16
4.1 Ерөнхий зүйл ........ 16
4.2 Материаллаг байдал ........ 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5.1 Төлбөрийн акт ........ 18
5.3 Зөвлөмж ........ 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/71

танай ____________ -ны №____________ -т

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
С.САМДАНЖИГМЭД
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

005020313

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.6 хувиар үнэлсэн байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **103,880,272.00** | **125,392,819.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 32,805,634.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 32,805,634.00 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 32,805,634.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 32,805,634.00 |
| **33** | **АВЛАГА** | 3,823,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 3,823,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 3,823,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 100,057,272.00 | 92,587,185.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,642,700.00 | 4,006,593.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 3,296,043.00 |
| 35130 | Эм боох материал | 1,642,700.00 | 710,550.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 98,414,572.00 | 88,580,592.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,974,730.00 | 780,040.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,204,350.00 | 2,122,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,883,800.00 | 590,550.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,003,490.00 | 8,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 83,348,202.00 | 85,078,602.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,375,489,250.23** | **1,454,256,428.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,375,489,250.23 | 1,454,256,428.09 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,358,893,250.23 | 1,437,660,428.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,464,064,429.64 | 1,484,064,429.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -207,616,794.43 | -277,851,578.13 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 158,679,167.00 | 276,050,167.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -106,156,810.89 | -122,504,950.43 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,383,850.00 | 107,613,850.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -49,033,763.85 | -54,616,246.11 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,630,248.00 | 11,630,248.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,832,942.24 | -11,501,358.88 |
| 39217 | Ном | 24,775,867.00 | 24,775,867.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,596,000.00 | 16,596,000.00 |
| 39301 | Программ хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,596,000.00 | 16,596,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,479,369,522.23** | **1,579,649,247.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **141,400.00** | **97,502.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 141,400.00 | 97,502.00 |
| **413** | **Өглөг** | 141,400.00 | 97,502.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 141,400.00 | 97,502.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,479,228,122.23** | **1,579,551,745.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,479,228,122.23 | 1,579,551,745.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 280,983,355.00 | 280,983,355.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 280,983,355.00 | 280,983,355.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -9,496,831.79 | 90,826,791.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -9,496,831.79 | -9,496,831.79 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 100,323,622.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,207,741,599.02 | 1,207,741,599.02 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,479,369,522.23** | **1,579,649,247.09** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **898,443,616.00** | **1,175,305,043.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,568,000.00** | **164,845,943.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 19,568,000.00 | 164,845,943.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 5,365,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,365,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **198,169,516.00** | **1,010,459,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 857,338,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 857,338,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 680,706,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 101,400,665.00 | 4,549,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 88,535,165.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,865,500.00 | 4,549,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 96,768,851.00 | 148,571,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 96,768,851.00 | 148,571,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **946,203,924.66** | **1,074,981,420.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **946,203,924.66** | **1,074,981,420.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 816,130,391.66 | 1,013,418,479.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 525,380,319.00 | 657,985,326.00 |
| 210101 | Үндсэн цалин | 525,380,319.00 | 445,841,419.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 168,078,327.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 13,947,460.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 30,118,120.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,192,608.00 | 83,125,493.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,422,710.00 | 56,870,141.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,311,541.00 | 6,662,812.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,245,873.00 | 5,303,372.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,019,317.00 | 1,299,016.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,193,167.00 | 12,990,152.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,268,851.00 | 105,188,843.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,476,314.00 | 4,673,870.00 |
| 210302 | Түлш, халаалт | 91,552,537.00 | 99,163,373.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 1,351,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,794,590.00 | 19,197,205.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,311,830.00 | 6,969,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,798,240.00 | 5,959,485.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,380,720.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,600.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 438,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,805,200.00 | 6,268,050.00 |
| **2105** | **Норматив зардал** | 14,302,720.00 | 30,100,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,128,700.00 | 1,433,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,874,020.00 | 28,667,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,079,000.00 | 7,882,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,079,000.00 | 7,882,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 446,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 446,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,144,875.00 | 6,277,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,644,875.00 | 1,542,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 4,735,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 93,521,428.66 | 103,660,162.14 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,570,000.00 | 10,826,340.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,834,400.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 90,117,028.66 | 92,833,822.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 130,073,533.00 | 61,562,941.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 109,376,490.00 | 49,275,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,697,200.00 | 49,275,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,272,400.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,789,890.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 617,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 3,823,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,823,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,549,500.00 | 8,464,941.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,147,543.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,147,543.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-47,760,308.66** | **100,323,622.86** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-47,760,308.66** | **100,323,622.86** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **878,875,616.00** | **1,019,648,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **5,365,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 5,365,900.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 5,365,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,365,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **878,875,616.00** | **1,014,282,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 857,338,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 857,338,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 680,706,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 101,400,665.00 | 8,372,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 88,535,165.00 | 3,823,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,865,500.00 | 4,549,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 96,768,851.00 | 148,571,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 96,768,851.00 | 148,571,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **866,064,316.00** | **971,425,366.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **866,064,316.00** | **971,425,366.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **732,167,783.00** | **909,862,425.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 525,238,917.00 | 657,887,824.00 |
| 210101 | Үндсэн цалин | 389,358,401.00 | 445,743,916.40 |
| 210102 | Нэмэгдэл | 97,059,383.00 | 168,078,327.60 |
| 210104 | Урамшуулал | 38,821,133.00 | 13,947,460.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 30,118,120.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,192,610.00 | 83,266,893.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,603,310.00 | 57,224,005.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,338,400.00 | 6,602,933.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,470,000.00 | 5,255,486.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,008,600.00 | 1,289,561.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,772,300.00 | 12,894,908.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,268,851.00 | 105,188,843.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,476,314.00 | 4,673,870.00 |
| 210302 | Түлш, халаалт | 91,552,537.00 | 99,163,373.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 1,351,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,866,840.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,191,280.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,798,240.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,380,720.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 360,600.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 438,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,698,000.00 | 00.00 |
| **2105** | **Норматив зардал** | 17,514,340.00 | 26,672,510.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,266,050.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,511,090.00 | 26,672,510.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,737,200.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,485,500.00 | 1,807,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 399,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,086,500.00 | 1,807,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 446,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 446,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,966,875.00 | 6,402,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,268,875.00 | 1,542,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 198,000.00 | 4,860,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,187,850.00 | 28,635,955.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,638,550.00 | 18,733,025.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,549,300.00 | 9,902,930.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **133,896,533.00** | **61,562,941.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 109,376,490.00 | 49,275,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,697,200.00 | 49,275,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,272,400.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,789,890.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 617,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 3,823,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,823,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 8,372,500.00 | 8,464,941.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,147,543.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,147,543.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,811,300.00** | **48,222,634.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,811,300.00** | **15,417,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,811,300.00** | **15,417,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,811,300.00 | 15,417,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,811,300.00 | 15,417,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,811,300.00** | **-15,417,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 32,805,634.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 32,805,634.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/ төгрөгөөр /**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 280,983,355.00 | 1,207,741,599.02 | 38,263,476.87 | 1,526,988,430.89 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **38,263,476.87** | **1,526,988,430.89** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -47,760,308.66 | -47,760,308.66 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **-9,496,831.79** | **1,479,228,122.23** |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **-9,496,831.79** | **1,479,228,122.23** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **-9,496,831.79** | **1,479,228,122.23** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 100,323,622.86 | 100,323,622.86 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **90,826,791.07** | **1,579,551,745.09** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,007,452,500.00** | **966,181,925.00** | **-41,270,575.00** | **95.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,007,452,500.00** | **966,181,925.00** | **-41,270,575.00** | **95.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **954,395,300.00** | **916,906,925.00** | **-37,488,375.00** | **96.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **687,062,200.00** | **657,887,824.00** | **-29,174,376.00** | **95.8** |
| 210101 | Үндсэн цалин | 489,201,600.00 | 445,743,916.40 | -43,457,683.60 | 91.1 |
| 210102 | Нэмэгдэл | 146,753,000.00 | 168,078,327.60 | 21,325,327.60 | 114.5 |
| 210104 | Урамшуулал | 13,434,400.00 | 13,947,460.00 | 513,060.00 | 103.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 37,673,200.00 | 30,118,120.00 | -7,555,080.00 | 79.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **85,882,800.00** | **83,266,893.00** | **-2,615,907.00** | **97.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,400,300.00 | 57,224,005.00 | -1,176,295.00 | 98.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,870,600.00 | 6,602,933.00 | -267,667.00 | 96.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,496,600.00 | 5,255,486.00 | -241,114.00 | 95.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,374,100.00 | 1,289,561.00 | -84,539.00 | 93.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,741,200.00 | 12,894,908.00 | -846,292.00 | 93.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **105,188,900.00** | **105,188,843.00** | **-57.00** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,525,500.00 | 4,673,870.00 | 148,370.00 | 103.3 |
| 210302 | Түлш, халаалт | 99,163,400.00 | 99,163,373.00 | -27.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,351,600.00 | -148,400.00 | 90.1 |
| **2105** | **Норматив зардал** | **27,582,200.00** | **26,672,510.00** | **-909,690.00** | **96.7** |
| 210502 | Хоол, хүнс | 27,582,200.00 | 26,672,510.00 | -909,690.00 | 96.7 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **988,000.00** | **-12,000.00** | **98.8** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 988,000.00 | -12,000.00 | 98.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,145,000.00** | **6,402,900.00** | **-1,742,100.00** | **78.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,542,900.00 | 1,542,900.00 | 00.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,602,100.00 | 4,860,000.00 | -1,742,100.00 | 73.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **39534200.00** | **36499955.00** | **-3,034,245.00** | **92.3** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,631,100.00 | 26,597,025.00 | -3,034,075.00 | 89.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,903,100.00 | 9,902,930.00 | -170.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,057,200.00** | **49,275,000.00** | **-3,782,200.00** | **92.9** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **53,057,200.00** | **49,275,000.00** | **-3,782,200.00** | **92.9** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 53,057,200.00 | 49,275,000.00 | -3,782,200.00 | 92.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,007,452,500.00** | **998,987,559.00** | **-8,464,941.00** | **99.2** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **857,338,300.00** | **857,338,300.00** | **00.00** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 857,338,300.00 | 857,338,300.00 | 00.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **148,571,300.00** | **140,106,359.00** | **-8,464,941.00** | **94.3** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 148,571,300.00 | 140,106,359.00 | -8,464,941.00 | 94.3 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,542,900.00** | **1,542,900.00** | **00.00** | **100.0** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,542,900.00 | 1,542,900.00 | 00.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **47.00** | **47.00** | **00.00** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 | 00.00 | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **437.00** | **406.00** | **-31.00** | **92.9** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **437.00** | **406.00** | **-31.00** | **92.9** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 437.00 | 406.00 | -31.00 | 92.9 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **47.00** | **47.00** | **00.00** | **100.0** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 33.00 | 33.00 | 00.00 | 100.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 13.00 | 00.00 | 100.0 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **101,400,665.00** | **8,372,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **101,400,665.00** | **8,372,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 12,865,500.00 | 8,372,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,865,500.00 | 8,372,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,865,500.00 | 8,372,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 88,535,165.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,535,165.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 88,535,165.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **101,400,665.00** | **8,372,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **101,400,665.00** | **8,372,500.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 88,535,165.00 | 3,823,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,865,500.00 | 4,549,500.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь " Сургалтын таатай орчин бүрдүүлсэн, чадвартай хөгжсөн багш ажилтантай, чанартай хүртээмжтэй сургалттай, стандартын шаардлагыг жигд хангасан, хүүхдэд ээлтэй сургууль болно" гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022-2023 оны хичээлийн жилд өдрөөр 406 хүүхэд, 80 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 50 хүүхэд, 1-5 дугаар ангийн 236 хүүхэд үдийн цай хөтөлбөрт хамрагдсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор гарсан Засгийн газрын "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах" тухай 91, 2022.06.29-ны өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" 252-р тогтоол, салбарын сайдын "Заавар батлах тухай" 2022.05.12-ны өдрийн А/170, "Журам шинэчлэн батлах тухай" 2022.11.14-ны өдрийн А/465, "Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" 2022.04.01-ний өдрийн А/122 "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам" 2022.10.26-ны өдрийн А/430, БШУС, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай" 2022.06.29-ны өдрийн А/238, А/340 зэрэг тушаал шийдвэрүүд шинээр батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн БШУЯ-ны дотоод аудит хэрэгжүүлдэг бөгөөд тус сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээр бүртгэлд тусган тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,579,649.2 мянган төгрөг болж өмнөх оноос 100,279.7 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 32,805.6 | 32,805.6 |
| Авлага | 3,823.0 | - | (3,823.0) |
| Бараа материал | 100,057.2 | 92,587.2 | (7,470.0) |
| Үндсэн хөрөнгө | 1,749,429.6 | 1,921,030.6 | 171,601.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (373,940.3) | (466,774.1) | (92,833.8) |
| **Нийт хөрөнгө** | **1,479,369.5** | **1,579,649.2** | **100,279.7** |
| Өр төлбөр | 141.4 | 97.5 | (43.9) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,479,228.1 | 1,579,551.7 | 100,323.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,479,369.5** | **1,579,649.2** | **100,279.7** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 32,805.6 мянган төгрөг болж өссөн нь төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмээгдсэн зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнадаг болсонтой холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 3,823.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх нэмэлт санхүүжилтийн дансны санхүүжилтийн авлага тайлант онд барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92,587.2 мянган төгрөг болж өмнөх оноос 7,470.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 95,689.6 мянга, 1-5 дугаар ангийн сурах бичиг 3,296,0 мянган төгрөгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, 106,455.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Үүнээс тусгай зориулалтын материал 3,296.0 мянга, бусад хангамжийн материал 1,730.4 мянган төгрөгөөр өссөн голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,921,030.6 мянган төгрөг болж өмнөх оноос 171,601.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотой нөхөн хангалтын зардлын санхүүжилтээр ерөнхий гэрээний дагуу худалдан авсан 11,687.0 мянган төгрөгийн цахим танхимын таблет, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,730.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 22,738.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар Хонгорын тогтвортой хөгжил төрийн бус байгууллагаас 79,386.0 мянган төгрөгийн компьютер, дэлгэц, 29,250.0 мянган төгрөгийн ангийн самбар, жилийн эцсийн тооллогоор илэрсэн 3,560.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,250.0 мянган төгрөгийн тавилга хэрэгслийн данс бүртгэлд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд 141.4 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бөгөөд тайлант хугацаанд 97.5 мянган төгрөг болж 43.9 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбогдсон 97,5 төгрөгийн өглөг нь жирэмсэн амаржсаны чөлөөтэй байсан багш Т.Наранцаралын ээлжийн амралтаас тооцсон ХАОАТ-г төлөөгүй орхигдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,579,551.7 мянган төгрөг болж 100,323.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 100,323.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,009,734.4 мянга төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 258,920.3 мянган төгрөгөөр бууруулж 750,814.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 857,338.3 мянган төгрөг болгож 106,524.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь төсвийн шинэчлэлтэй холбоотой сургуулийн суралцагчдын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848, 81844, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,007,452.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 858,881.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 148,571.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 858,881.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 148,571.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 826,081.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 140,106.4 мянган төгрөгийг зарцуулж 8,464.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 966.187.7 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 32.805.6 мянган төгрөгөөр орон нутгийн урсгал зардлыг 8.464.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 80111 | Нийтлэг үйлчилгээ | 148,571.3 | 140,106.3 | 6,701.0 | 94.3% |
| 2 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 2,640.8 | 2,640.8 | 0,0 | 100% |
| 3 | 80312 | Сургалт семинар | 1,320.4 | 921.5 | 398.9 | 69.8% |
| 4 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих зардал | 3,037.0 | 840.0 | 2,197.0 | 27.6% |
| 5 | 81801 | Үдийн цай хөтөлбөр | 53,057.2 | 49,275.0 | 3,782.2 | 92.9% |
| 6 | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 43,947.3 | 43,037.5 | 909.7 | 97.9% |
| 7 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 11,990.0 | 11,687.0 | 303.0 | 97.5% |
| 8 | 81823 | Боловсролын байгууллагын багш | 5,941.9 | 5,815.4 | 126.4 | 97.9% |
| 9 | 81834 | Боловсролын стандарт | 654,789.1 | 630,663.8 | 24,125.3 | 96.3% |
| 10 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 80,614.6 | 79,657.5 | 957.0 | 98,8% |
| 11 | 81848 | Сурах бичгийн түрээс | 1,542.9 | 1,542.9 | 0,0 | 100% |
| | | Дүн | 1,007,452.5 | 966,187.7 | 41,264.8 | 95.9% |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100031915401 дансаар 2022 оны байдлаар орлогоор тусгагдсан 3823.0 мянган төгрөг нь өмнөх оны дансны буцаан төвлөрүүлсэн 4549.5 мянган төгрөг төгрөгийг засвар үйлчилгээний зардалд зарцуулан үлдэгдэл 3823.0 мянган төгрөгийг үндсэн дансанд шилжүүлсэн байгаа.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төгрөгөөр/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Туслах үйл ажиллагааны орлого /хуучин барилга нураасан материал борлуулсан / | 4,549.50 |
| 2 | Өмнөх оны үлдэгдэл | 3,823.00 |
| | **Нийт орлогын дүн** | 8,372.50 |
| 1 | УТ-ын дансанд төвлөрүүлсэн | 3,823.00 |
| 2 | Бусад бараа үйлчилгээний зардал | 4549.5 |
| | **Нийт зарлагын дүн** | 8,372.50 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Самданжигмэд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч З.Саранчулуун нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,074,981.4 мянган төгрөгөөс 16,124.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 11,287.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл*

| Д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлбэл зохих/ удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Мэдээлэл байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 4 | 4 | 0 | 3 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | 2 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 | |
| | **Нийт** | **27** | **151** | **142** | **6** | **0** | **3** |

*Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн систем*

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 831,428.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна..

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн аудитын 2,000.0 мянга, нийцлийн аудитын 105,339.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022.05.28-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 2,000.0 | 0 | 2,000.0 | 0 |
| Зөвлөмж | 4 | 0 | 4 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **4** | **2,000.0** | **4** | **2,000.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар сарууддад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар дотуур байрны хоолны зардал 909,7 мянга, Үдийн цай хөтөлбөрийн зардал 3782,2 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,164.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 1 албан шаардлага, нийцлийн аудит буюу шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 831,424.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

### 5.1 Албан шаардлага

*Илрүүлэлт:* Тайланд хугацаанд 81823 буюу багшийн сургалтын зардлаас 248.8, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1001.0 мянга, Дотуур байрны бараа үйлчилгээний зардлаас 376,0, 80312 буюу сургалт семинарын зардлаас 471,5 мянга нийт 2164.0 мянган төгрөгийн шатахуун тус тус худалдан авч батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дугаар тогтоол, БСШУС-ын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### Нийцлийн аудиттай холбоотой асуудал

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

*Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 831428.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:*** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайланд хугацаанд 81823 буюу багшийн сургалтын зардлаас 248.8, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1001.0, Дотуур байрны бараа үйлчилгээний зардлаас 376,0, 80312 буюу сургалт семинарын зардлаас 471,5 нийт 2164.0 мянган төгрөгийн шатахуун тус тус худалдан авч батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 2,164.0 | 0 | 0 | 1 | 2,164.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | **Нийт дүн** | **2** | **2,164.0** | **0** | **0** | **1** | **2,164.0** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 831428.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |

oOo